



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 413

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөө аж ахуйн их сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн, Бурхантын ам, 21 дүгээр хороонд байрлалтай, нэгж талбарын 18623331621993 дугаартай, сургалтын зориулалттай, 140396 м.кв талбай бүхий газар эзэмших эрх болох нийт 359,413,760.00 (гурван зуун тавин есөн сая дөрвөн зуун арван гурван мянга долоон зуун жаран) төгрөгийн балансын үнэтэй биет бус хөрөнгийг Хөдөө аж ахуйн их сургуулийн дэргэдэх гарааны “Агро грийн хаус” хязгаарлагдмал хариуцлагатай компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Энэ тогтоолын 1 дүгээр заалтад заасан биет бус хөрөнгийг тус сургуульд дээр хэрэгжиж буй “Хүнсний ногооны хүлэмжийн жишиг парк, сургалт-үйлдвэрлэлийн төв” байгуулах инновацын төсөл хэрэгжиж дуусмагц (3 жил) гарааны “Агро грийн хаус” хязгаарлагдмал хариуцлагатай компаниас Хөдөө аж ахуйн их сургуульд балансаас балансад буцааж шилжүүлэхээр тогтсугай.

3.Газрын зориулалтыг өөрчлөх, бусдад дамжуулан түрээслэх, шилжүүлэх, худалдах, барьцаалахыг хориглосугай.

4.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Хөдөө аж ахуйн их сургууль болон гарааны “Агро грийн хаус” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн захирал Т.Хэрүүга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

4.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

4.2.Хуульд заасан гарааны компанийн эрх эдлэх хугацаа өнгөрмөгц компани нь ХХК хэлбэрээр үйл ажиллагаа үргэлжлүүлэн явуулах болон 100 хувь төрийн өмчит компанийн хөрөнгө, дүрэмд өөрчлөлт орохоор бол төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухай бүр мэдэгдэж зөвшөөрөл авах;

4.3.Энэ тогтоолын 2 дугаар заалтыг хэрэгжүүлж ажиллах;

4.4.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

000083

4.5.Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

5.Энэхүү тогтоолд заасан биет бус хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд урьдчилсан бүртгэл хийлгэх арга хэмжээ авах, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

